



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/762

Булган сум

Хилийн зурвас газарт байгалийн тэнцвэрийг хадгалах, хамгаалах зорилгоор хяналт шалгалт зохион байгуулахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны хуралдааны IX/26 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Тэшиг, Сэлэнгэ сумдын хилийн зурвас газарт байгалийн тэнцвэрийг хадгалах, хамгаалах зорилгоор хяналт шалгалт зохион байгуулахад 10,000,000 (арван сая) төгрөгийг зарцуулсугай .

2.Хяналт шалгалт зохион байгуулахад шаардлагатай 10,000,000 (арван сая) төгрөгийг Байгаль орчин хамгаалах, байгаль орчин нөхөн сэргээх зардлын сангаас санхүүжүүлэхийг сангийн нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Хилийн зурвас газарт хяналт шалгалтыг зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллахыг Тэшиг сум дахь Хилийн цэргийн 0286 дугаар ангийн захирагч(хурандаа Л.Цогтжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР